

МОНГОЛ УЛСЫН ХИЛ ОРЧМЫН БҮС НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

*Ч.Батцэцэг**

Өнөөдөр олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаанд бүс нутгийн хамтын ажиллагаа ялангуяа бүс нутгийн хөгжилд хөрш орнуудын хамтын ажиллагаа чухал болж байна. Манай улс газар зүйн нөхцөл байдлаар дэлхийн хоёр том гүрэн ОХУ, БНХАУ-тай хил залгадаг агаад хил орчмын бүс нутгийн уламжлалт харилцаа, хамтын ажиллагаанд хойд хөрш ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улс (БНБУ), урд хөрш БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орон (ӨМӨЗО) онцгой үүрэг гүйцэтгэсээр ирсэн.

Манай улстай хил залгаа БНБУ нь Оросын Алс Дорнод болон Сибирийн нөлөө бүхий улс учраас Оросын нутаг дэвсгэр дэх хөрш улсууд төдийгүй Азийн бусад орны харилцаа, хамтын ажиллагаанд чухал байр эзэлдэг. 2001 оны 2 дугаар сарын 9-ний өдөр ОХУ-ын Засгийн газраас баталсан “ОХУ-ын хил орчмын хамтын ажиллагааны үзэл баримтлал”-д “ОХУ-ын хил орчмын хамтын ажиллагаа хэмээх ойлголт нь хоёр талын хил орчмын бүсийн тогтвортой хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, орон нутгийн хүн амын аж байдлыг дээшлүүлэх, ОХУ-аас хил залгаа улстайгаа тогтоосон хамтын ажиллагаа, сайн хөршийн болон найрамдалт харилцааг бэхжүүлэхэд чиглэгдсэн тус улсын Холбооны Гүйцэтгэх засаглал, субъектуудийн Гүйцэтгэх засаглал орон нутгийн байгууллагуудын зөвшилцсөн үйл ажиллагаа юм”¹ гэж тодорхойлжээ. ОХУ субъектуудынхээ гадаад хэлхээ холбоог зохицуулах арга ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор Олон улсын болон гадаад эдийн засгийн харилцааны асуудлаар Холбооны Субъектуудын Зөвлөлдөх Зөвлөлийг байгуулан ажиллаж байна. Мөн Буриад улсын геополитикийн байдал, түүний хөршүүдийн (Монгол, Хятад болон Ази-Номхон далайн бүс нутаг) уламжлалт харилцааны онцлогийг харгалзан ОХУ-ын Холбооны хууль тогтоолоор олон улсын болон гадаад эдийн засгийн харилцааны салбарт тус улс бие даасан бүрэн эрхт үйл ажиллагаа явуулахыг тусгайлан анхаарч, ОХУ-ын Засгийн газар, БНБУ-ын засгийн газар хоорондын хэлэлцээр хийжээ.²

БНБУ уул уурхай, ой модны үйлдвэрлэл, эрчим хүчний эх булагтай, газар тариалан, хөдөө аж ахуйн орон учраас уул уурхай, өнгөт төмөрлөг, мод боловсруулалт, хөнгөн хүнсний үйлдвэр зэрэг салбар түлхүү хөгжсөн ба нарийн ноост хонь, үхрийн аж ахуй голлон эрхэлдэг. Гадаадад голдуу цахилгаан хөдөлгүүр, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, цахилгаан эрчим хүч, шил шифер, зам гүүрийн төмөр

* Ч.Батцэцэг - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

эдлэл, картон, мод, зүсмэл модон бүтээгдэхүүн, загасны нөөш зэрэг бүтээгдэхүүн нийлүүлдэг аж.

БНБУ-ын эдийн засгийн гол түнш нь хөрш Монгол, Хятад улс бөгөөд нийт экспортын 10.4%, импортын 14.4% нь Монгол Улсад ногдож байна.

Буриад улс, манай улстай хамтран явуулж буй үйл ажиллагааны ерөнхий байдлыг 2004 оны тоон үзүүлэлтээр авч үзье. Тухайлбал: 2004 онд хоёр улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд Буриадын гүйцэтгэх засаглалын 9 байгууллага, орон нутгийн өөрөө удирдах засаглалын 14 байгууллага оролцжээ.

Монгол Улсад БНБУ-ын янз бүрийн шатны 95 төлөөлөгч, түүн дотор БНБУ-ын ерөнхийлөгч Л.В.Потапов, орлогч дарга Л.Д.Турбянов, О.В.Хышиктуев, Хороодын дарга, сайд, орлогч С.Д.Намсараев, В.В.Бубнов, А.О.Занданов, А.А.Лехатинов, П.Л.Носков болон Буриадын засаг захиргааны нэгжийн тэргүүнүүд (Жидинск, Бичурск, Еравнинск, Тарбагатай, Кижингинск, Хоринск, Курумканск, Прибайкальск, Хиагт) айлчилжээ. Мөн хугацаанд ОХУ-ын БНБУ-ын ерөнхийлөгч Л.В.Потаповыг Монгол Улсад айлчлах үеэр хоёр улсын найрсаг харилцааг бэхжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Монгол Улсын төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор шагнасныг ерөнхийлөгч Н.Багабанди гардуулж³ өгсөн юм.

Монголоос тухайн жилд үндсэндээ шинжлэх ухаан, боловсрол, соёлын салбарыг төлөөлсөн 33 зүтгэлтэн Буриадад зочилсон байна.

Хоёр талын айлчлалын хүрээнд гүйцэтгэх засаглалын байгууллагын 9 Протокол болон Монгол Улсын аймгуудтай Буриадын өөрөө удирдах орон нутгийн байгууллагуудын хоорондын 10 гэрээнд гарын үсэг зуржээ.

Боловсрол, шинжлэх ухааны салбарт 11, соёл, спорт-биеийн тамирын чиглэлээр 24, үзэсгэлэн яармаг 9, хүүхэд багачуудын амралтыг зохион байгуулах гэх мэт хамтарсан үйл ажиллагаа явуулсан байна.

Буриад улсын Эрүүл мэндийн яамнаас 220295 ам.долларын эмнэлгийн хэрэгсэл, эм тариа нийлүүлж, 140 сувилагч, 43 эм найруулагч, эмийн санчийг сургалтанд хамруулжээ. Барилгын яамнаас 38 вагон шифер эдлэл (1525 мянган плита) нийлүүлсэн байна. Хүнс хөдөө, аж ахуйн яам Монголоос 370 тн өвс татаж авсан ба Монголд 70 толгой гахай, 1503 тн чихэр, 1544 тн гоймон хүнсний бүтээгдэхүүн нийлүүлсэн. Аж үйлдвэрийн яамнаас нэг нисдэг тэрэгт засвар хийж, 9,5 мян.куб хөрөөдсөн мод (ой модны экспортын 1%) нийлүүлжээ.⁴

Төл малыг тэжээх, мах, сүүний чиглэлийн төл малыг өсгөж бойжуулахад зориулсан үр тарианы “Монголбуриадагро” 100 мянган ам.долларын дүрмийн сантай хамтарсан компанийг Сэлэнгэ аймгийн Алтанбулаг хотод байгуулсан байна.

Улаан-Үд хотод Улаанбаатар, Дархан, Эрдэнэ хотын өдрүүд, Монголын аймаг, Буриадын хилийн дүүргүүдэд “Эв мод нийлүүлэх” баярыг зохион байгуулж иржээ.

Ийнхүү Монгол Улс, ОХУ-ын БНБУ-ын хооронд уламжлалт харилцаа бүхий л хүрээг хамран жилээс жилд идэвхжин хөгжиж байгаа боловч цаашдын хамтын ажиллагаагаа улам өгөөжтэй, үр ашигтай болгох, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Ялангуяа манай улсын уламжлалт бараа малын ашиг шим (мах, ноос, арьс шир), түүгээр хийсэн бэлэн бүтээгдэхүүнийг экспортоор нийлүүлэхэд Оросын талын татварын өндөр шаардлагаас улбаалан тэр бүр хэрэгжиж чаддаггүй. Иймээс хамтын ажиллагааны шинэ шинэ хэлбэрийг эрэлхийлэн харилцан ашигтай байх, хил орчмын ард иргэд харилцан хамтын ажиллагаа явуулах хууль зүйн үндсийг баталгаатай болгох, худалдаа эдийн засгийн чөлөөт бүс байгуулж, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх гэх мэт наад захын бодитой ажил үйлс хэрэгтэй болж байна.

Монгол Улс хил залгаа БНХАУ-ын ӨМӨЗО-той худалдаа, эдийн засаг, соёл, боловсролын салбарын хамтын ажиллагаагаа өргөжүүлж байна.

ӨМӨЗО нь Хятад улсынхаа дотор “хойд 3 бүс”-ийн заагт оршдог бөгөөд дотоодын 8 мужтай залгаж, зүүнтэйгүүр далайн тойргийн эдийн засгийн хүрээнд багтдаг Бээжин, Тяньжин, Таншань зэрэг зүүн гурван мужийн хотуудтай ойр, баруугаараа “алтан гурвалжин” бүсийн Баолан төмөр замаас хамааралтай Сылун, Хайлан зэрэг эдийн засгийн шинэ бүсэд багтаж, улсынхаа баруун бүсийн хөгжлийг эрчимжүүлэх төсөлд чухал ач холбогдолтой болж байгаа бөгөөд хойгуураа Орос, Монгол хоёр улстай хиллэдэг.⁵ Иймээс Хятадын дотоодын эдийн засгийг хөгжүүлэхэд тус өөртөө засах орны газар зүйн байршил чухалд тооцогддог.

ӨМӨЗО-д Хятадын баруун бүс нутгийг хөгжүүлэх стратегийн төлөвлөгөө, нээлттэй байх бодлого хэрэгжүүлснээр, гадаадад эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааны харьцангуй бие даасан бодлого явуулж байна.

Өвөр Монгол нь газар зүйн байршлын давуу талаа ашиглан 2004 онд Орос, Монгол хоёр улстай хийсэн худалдааны нийт хэмжээ 1.9 тэрбум ам.долларт хүрч, ӨМӨЗО-ы гадаад худалдааны нийт эргэлтийн 47 хувийг эзэлж, худалдааны нэгдүгээр түнш ОХУ, гуравдугаар түнш нь Монгол Улс болжээ.⁶

2004 оны 10 дугаар сард ӨМӨЗО-ы дарга Янь Жин тэргүүтэй өөртөө засах орны засгийн газрын төлөөлөгчид Монгол Улсад ажлын айлчлал хийв. Айлчлалын үеэр Монгол Улс, ӨМӨЗО-ы хооронд эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа алхам алхмаар хөгжих нөхцөл бүрдэж байгааг хоёр талын тэргүүн нар онцлон тэмдэглэсэн юм.

Өвөр Монголын эдийн засаг, худалдааны танхимын нэгдсэн дүнгээр Монгол Улсад Хятадаас оруулж буй импортын барааны үнийн дүнгээр Өвөр Монгол ойролцоогоор 70% эзэлж байна гэсэн тооцоо гарчээ. Монгол Улсын зах зээлд Өвөр Монголын үйлдвэр, аж ахуйн

газрууд элсэн чихэр, хүнсний ногоо, гурилыг голлон нийлүүлж байна. 2004 оны эхнээс дөнгөж боомт газрыг байнгын ажиллагаатай болгосноор эхний улиралд импортын барааны нийт хэмжээ 2003 оныхоос 150%-иар нэмэгдсэн байх жишээтэй. ӨМӨЗО-ы үйлдвэрүүдээс Монгол Улсад нийлүүлж байгаа бүтээгдэхүүнд Монгол Улсын Үндэсний тохирлын тэмдэг олгох, баталгаажуулах ажлыг зохион байгуулж байгаа ажээ.

Монгол Улс, ӨМӨЗО-ы хоорондын соёл, боловсрол шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа харьцангуй эрчимтэй хөгжиж, идэвхтэй үйл ажиллагаа явуулж буйг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

БНХАУ-ын дотоодын зах зээлд уул уурхайн бүтээгдэхүүн, түүхий эдийн зах зээлийн хэрэгцээ, эрчим хүчний нөөц өсөн нэмэгдэж байгаатай уялдуулан ӨМӨЗО-ы хөрөнгө оруулалтыг зөвхөн хүнсний хэрэгцээгээр хязгаарлахгүй цаашид манай улсын уул уурхай, ашигт малтмалын орд газруудыг хамтран ашиглахад зориулж, томоохон төслүүдийг хэрэгжүүлэх, хилийн боомт газруудын дэд бүцийн бүтээн байгуулалт, аялал жуулчлалын салбарт өргөнөөр татан оролцуулах явдал чухал юм.

Хойд хөрш ОХУ-ын БНБУ, урд хөрш БНХАУ-ын ӨМӨЗО-ы хамтын ажиллагааны тухайд авч үзвэл, Оросын Холбооны БНБУ-ын засгийн газар, БНХАУ-ын ӨМӨЗО-ы засгийн газрын хооронд 2003 оны 12 дугаар сарын 22-нд Хөххотод Худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан техник болон соёлын хамтын ажиллагааны Гэрээ байгуулж, И.М.Егоров, Юэ Фухун нар гарын үсэг зуржээ. Мөн 2004 оны 10 дугаар сарын 4-нд Улаан-Үд хотод хоёр талын худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёлын хамтын ажиллагааны Хөтөлбөр болон Протоколд БНБУ-ын ерөнхийлөгч Л.В.Потапов, ӨМӨЗО-ы дарга Янь Жин нар гарын үсэг зурсан байна.

Мөн 2004 оны 10 дугаар сард БНХАУ-ын ӨМӨЗО-ы дарга Янь Жин тэргүүтэй төлөөлөгчид, 11 дүгээр сард Манжуур хотын Намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ян Ханьжун тэргүүтэй төлөөлөгчид, 12 дугаар сард ӨМӨЗО-ы Худалдаа удирдах газрын орлогч дарга Ма Юньсянь тэргүүтэй төлөөлөгчид тус тус Улаан-Үд хотод айлчилжээ.

Улаан-Үд хот, Чаньчунь хотын хооронд ах дүүгийн харилцаа тогтоох гэрээ байгуулж, 2001-2004 онд хамтран ажиллах тухай хэлэлцээрийг 2001 оны 9 дүгээр сарын 5-нд хийсний сацуу мөн Улаан-Үд хот, Хөххотын хооронд ах дүүгийн холбоо тогтоох тухай гэрээг 2000 оны 12 дугаар сарын 6-нд байгуулсан бол 2001 онд Хөлөнбуйр аймагтай, Эвенкийн өөртөө засах хошуутай тус тус хамтран ажиллах хэлэлцээр хийжээ.

Буриад улсын нутаг дэвсгэрт гадаадын хөрөнгө оруулалттай хамтарсан үйлдвэр, аж ахуйн 45 газар бүртгүүлснээс 19 нь БНХАУ-ын хөрөнгө оруулалтаар үйл ажиллагаа явуулж байна. Тэдгээрийн зургаад нь ӨМӨЗО хөрөнгө оруулжээ. Нийтдээ 11,0 мянган ам.долларын үндсэн хөрөнгө бүрдүүлсний дотор Өвөр Монголын хөрөнгө оруулалт 8,65

мянган доллар байгаа нь Буриад улсын эдийн засагт оруулж буй гадаадын шууд хөрөнгө оруулалтын нийт хэмжээний 0,6%-ийг эзэлж байна.

Буриад улсаас БНХАУ-д экспортын үндсэн бүтээгдэхүүн болох мод, зүсмэл материал нийлүүлж, 2004 оны 9 сарын хугацаанд Хятадад 3898,7 мянган долларын 667,6 мянган куб.м зүсмэл, 4036,2 мянган долларын 33,4 мянган тн зүсмэл материал экспортоор гаргажээ.⁷

Аялал жуулчлалын салбарт 2004 онд Буриад улсаас 9250 хүн Өвөр Монголд жуулчилсан бол тэндээс 2760 жуулчин ирсэн гэсэн мэдээ бий.

Буриадын Багшийн коллежи, Манжуурын Багшийн коллежийн хооронд хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийг 2004 оны 4 дүгээр сард хийсэн байна. Буриадын театрын болон уран бүтээлчдийн хамтлаг Өвөр Монголд 6 удаа аялан тоглолт хийж, улмаар “Сагаалган” (“Цагаан сар”), “Хотын өдрүүд”-эд зориулсан арга хэмжээ зохион байгуулж, Улаан-Үд хотод 3 удаа олон улсын чөлөөт бөх, бокс, гар бөмбөгийн тэмцээн явуулж, боксийн төрлөөр хамтран бэлтгэл сургууль хийжээ.

Улаан-Үдийн автотээврийн 2 дугаар салбар Улаан-Үд, Манжуурын хооронд тогтмол зорчигч тээвэрлэх эрхийг аваад үйлчилж байна. “Востсибрыбцентр” хэмээх байгууллагаас Өвөр Монголд амьд түрс, омор загас, пелядийг 3 сая ширхэгийг нийлүүлжээ.⁸

Бид Монгол - Буриад, Монгол - Өвөр Монгол, Буриад - Өвөр Монголын хоорондын харилцаа, эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны талаархи мэдээлэл, тоо баримтыг зөвхөн нэг жилийн буюу 2004 оны байдлаар авч үзлээ. Үүнээс үзэхэд, Монгол Улсын хил орчмын бүс нутгийн харилцаа, хамтын ажиллагаа харьцангуй амжилттай хэрэгжиж байгаа дүр зураг харагдаж байна.

Манай улсын хил залгаа ОХУ-ын БНБУ, БНХАУ-ын ӨМӨЗО нь хоёулаа улсынхаа хувьд алсагдсан, хөгжлөөр хоцрогдсон, ДОХ-ын тархалтаар дээгүүрт ордог боловч үндэсний асуудал, шашин шүтлэгийн хувьд харьцангуй тогтвортой, тайван бүс нутаг юм. Цаашид манай улсын хил орчмын бүс нутгийн хамтын ажиллагаанд хоёр хөршийн ард иргэдийн хэл, соёл, түүхэн уламжлал, ёс заншил, ахуй амьдралын хэв загварын давуу чанар бие биеэ ойлгоход дөхөмтэй байдал чухал үүрэг гүйцэтгэх ёстой. Иймээс манай улс хил орчмын бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх гол ажлыг үүсгэн санаачилж, үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах үүднээс хамтын ажиллагааны чиглэл, төрөл зүйлийг тодорхойлон, монгол угсаатны хүрээнд гурван талын хамтарсан арга хэмжээ зохион байгуулж, чөлөөт худалдаа эрхлэх, хөрөнгө оруулалтыг илүү ихээр татах тааламжтай нөхцөл бүрдүүлэх, хэв журам, хууль зүйн үндсийг боловсронгуй болгох, орон нутгийн хэмжээнд бүсийн байгаль экологийн хүчин зүйлийг тооцоолон, мал аж ахуй, хөдөө аж ахуй, аялал жуулчлал болон бусад салбарт олон

хэлбэрийн сонирхолтой, өгөөжтэй, үр ашигтай, идэвхтэй үйл ажиллагаа явуулахыг төр засаг, орон нутгийн засаг захиргаанаас дэмжих нь зүйтэй.

ИШЛЭЛ, ЗУУЛТ

1. “Олон улс судлал” сэтгүүл. 2005 №1 т.26
2. Д.А.Ивайловский. Российский федерализм-проблемы становления и развития. “Президентская власть в Бурятии” Улан-Удэ. 2000. стр.38
3. “Өдрийн сонин” 2004.4.2 №217 (1719)
4. <http://economy.buryatia.ru:8085/attacheddocuments/arvmitogi-2004.2/> официальный сайт Министерства экономического развития и внешних связей Республика Бурятия (Инф. по сотрудничеству с АРВМ КНР за 2004 г).
5. “Олон улс судлал” сэтгүүл. 2005 №3. т. 21
6. Мөн тэнд. т.49
7. <http://economy.buryatia.ru:8085/attacheddocuments/arvmitogi-2004.2/> официальный сайт Министерства экономического развития и внешних связей Республика Бурятия (Инф. по сотрудничеству с АРВМ КНР за 2004 г).
8. <http://economy.buryatia.ru:8085/attacheddocuments/arvmitogi-2004.2/> официальный сайт Министерства экономического развития и внешних связей Республика Бурятия (Инф. по сотрудничеству с АРВМ КНР за 2004 г).